

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/01-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Сүхбаатар сум
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 70363040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 70363036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
Аудитор: Ж.Цогт
Утас: 70362442 Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	6-8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	9-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	9-10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт..	10-14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14-17
4. Аудитын тайлан.....	17-19
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	17-18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18-19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. Аудитын илрүүлэлт	19-24
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.25 № СЭА-2024/01-НА-СТА-ТТЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны үйл ажиллагаанд зарцуулахаар 2,139,512.5 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 1,941,601.7 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн гүйцэтгэл 90.7 хувьтай тайлагнагдсан бөгөөд батлагдсан төсвийг 197,910.8 мянган төгрөгөөр буюу 9.3 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Сумын ЗДТГ нь тоног төхөөрөмж худалдан авахад тавилга хэрэгслийн зардлаас 11,655.4 мянган төгрөг, урсгал засварын зардлаас 2,250.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын ИТХ нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг “Хангалттай” гэж дүгнэсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын хяналт шалгалт, үнэлгээний дүнгээр тус сумын 2023 оны үйл ажиллагааг 86.2 хувиар үнэлж, сумдын хүрээнд 10 дугаарт шалгарсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	655,273.7	449,557.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	381,169.2	239,304.6
33	АВЛАГА	206,980.6	143,515.6
35	БАРАА МАТЕРИАЛ	67,124.0	66,737.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,763,748.0	2,237,813.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,763,748.0	2,237,813.8
39200	Биет хөрөнгө	1,662,527.2	2,086,668.0
39300	Биет бус хөрөнгө	101,220.8	151,145.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,419,021.7	2,687,371.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,200.6	732.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,200.6	732.3
41300	Өглөг	2,200.6	732.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,416,821.1	2,686,638.9
51	Засгийн газрын хувь оролцоо	2,416,821.1	2,686,638.9
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,269,358.1	1,269,358.1
51200	Хуримтлагдсан үр дүн	256,714.8	526,532.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	890,748.2	890,748.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,419,021.7	2,687,371.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,872,305.5	2,621,519.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	641,287.7	565,019.1
110	Орлогын албан татвар	393,836.8	385,431.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	393,836.8	432,702.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(47,271.7)
113	Хөрөнгийн албан татвар	51,621.1	59,312.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	195,829.9	120,275.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	203,260.0	853,610.1
120	Нийтлэг татварын бус орлого	179,060.0	853,610.1
122	Тусламжийн орлого	24,200.0	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,027,757.9	1,202,890.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,897,914.3	1,835,025.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,529,831.6	1,690,951.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,496,596.2	1,671,859.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	426,486.6	504,772.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,808.8	66,852.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	332,562.1	80,236.8
2104	Хангамж, бараа материалын зардал	28,069.2	46,654.7
2105	Нормативт зардал	875.4	1,151.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,774.3	5,887.5
2107	Томилолт, зочны зардал	5,572.8	5,525.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	125,087.4	549,593.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	460,359.6	411,185.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,235.4	19,091.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	368,082.7	144,074.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(25,608.8)	786,494.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,702,184.2	516,676.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(4,727,792.9)	269,817.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,139,401.6	-	7,139,401.6
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,416,821.1	-	2,416,821.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,144,614.0	-	7,144,614.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	5,212.5	-	5,212.5
9	Тайлант үеийн үр дүн	(4,727,792.9)	-	(4,727,792.9)
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,416,821.1	-	2,416,821.1
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,686,638.9	-	2,686,638.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,416,821.1	-	2,416,821.1
19	Тайлант үеийн үр дүн	269,817.8	-	269,817.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,860,457.1	1,965,164.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	641,287.7	565,019.1
110	Орлогын албан татвар	393,836.8	385,431.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	393,836.8	432,702.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(47,271.7)
113	Хөрөнгийн албан татвар	51,621.1	59,312.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	195,829.9	120,275.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	35,268.3	26,391.6
1181	Газрын төлбөр	46,002.8	42,954.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	114,558.8	50,929.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	195,944.6	197,254.2
120	Нийтлэг татварын бус орлого	171,744.6	197,254.2
122	Тусламжийн орлого	24,200.0	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,023,224.8	1,202,890.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,116,765.8	1,316,865.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,116,765.8	1,316,865.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,083,075.6	1,297,773.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	419,128.6	506,120.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,935.9	66,852.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	332,050.6	70,910.8
2104	Хангамж, бараа материалын зардал	32,651.2	33,469.4
2105	Нормативт зардал	159.0	7.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	86,541.8	19,584.9
2107	Томилолт, зочны зардал	5,572.8	5,363.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58,143.2	554,398.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	94,892.5	41,066.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,690.3	19,091.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	743,691.3	648,298.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	589,610.6	790,163.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	589,610.6	790,163.0
2200	Дотоод эх үүсвэрээр	589,610.6	790,163.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(589,610.6)	(790,163.0)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	154,080.6	(141,864.5)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	227,088.6	381,169.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	381,169.2	239,304.6

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,139,512.5	1,941,601.7	197,910.8	90.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,394,684.7	1,307,165.1	87,519.6	93.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,375,569.1	1,288,073.5	87,495.6	93.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	534,264.9	506,120.5	28,144.4	94.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,975.9	66,852.1	5,123.8	92.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	505,224.3	501,011.8	4,212.5	99.2
2104	Хангамж, бараа материалын зардал	37,090.1	32,463.4	4,626.7	87.5
2105	Нормативт зардал	330.7	7.3	323.4	2.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,050.9	43,946.5	2,104.4	95.4
2107	Томилолт, зочны зардал	6,966.4	5,363.9	1,602.5	77.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	100,485.9	91,241.3	9,244.6	90.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	73,180.0	41,066.6	32,113.4	56.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,115.6	19,091.6	24.0	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,115.6	19,091.6	24.0	99.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	654,827.8	634,436.6	20,391.2	96.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	90,000.0	-	90,000.0	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,139,512.5	1,915,106.3	224,406.2	89.5
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,765,993.4	1,845,779.4	(79,786.0)	104.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	373,519.1	69,327.0	304,192.1	18.6
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	203,638.8	(203,638.8)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	177,143.5	(177,143.5)	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	170,580.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	37,866.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,712.5
2104	Хангамж, бараа материалын зардал	1,006.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,706.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,154.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,154.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	132,714.4
2200	Дотоод эх үүсвэрээр	132,714.4
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	170,580.8
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	170,580.8

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Алтанбулаг сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх, боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлж, мэргэшсэн тогтвортой, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг дэвшүүлж, хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, даван сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр ТБОНӨХБАҮХАТ хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт нь оновчтой боловч хэрэгжилтийн үр нөлөө сул байна гэж үзлээ.

2023 онд тус ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй боловч ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод хяналт, шалгалтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналт, шалгалтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанбулаг сумын ТТЗ нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Алтанбулаг сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”- ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн

захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 268,349.5 мянган төгрөгөөр буюу 11.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	381,169.2	239,304.6	(141,864.6)
Авлага	206,980.6	143,515.6	(63,465.0)
Бараа материал	67,124.0	66,737.2	(386.8)
Үндсэн хөрөнгө	1,763,748.0	2,237,813.8	474,065.8
Нийт хөрөнгө	2,419,021.7	2,687,371.2	268,349.5
Өр төлбөр	2,200.6	5,886.3	3,685.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,416,821.1	2,686,638.9	269,817.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,419,021.7	2,687,371.2	268,349.5

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансад бөгөөд өөрчлөлтийг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 239,304.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 141,864.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	381,169.2	239,304.6	(141,864.6)
Төгрөг	381,169.2	239,304.6	(141,864.6)
Төрийн сангийн харилцах	381,169.2	239,304.6	(141,864.6)
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Дүн	381,169.2	239,304.6	(141,864.6)

Эх сурвалж: Алтанбулаг сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд тайлагнагдсан Орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 62,161.2 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 25,391.1 мянган төгрөг, хоршоог хөгжүүлэх сангийн үлдэгдэл 151,752.3 мянган төгрөг тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 143,515.6 мянган төгрөг болж, өмнөх оноос

63,465.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагаас авах авлага	5,482.8	3,426.1	(2,056.7)
Хувь хүмүүсээс авах авлага	201,497.7	140,089.4	(61,408.3)
Дүн	206,980.6	143,515.6	(63,465.0)

Эх сурвалж: Алтанбулаг сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны нийт авлагын эцсийн үлдэгдлийн 96.5 хувь буюу 140,089.4 мянган төгрөгийг ХХС-ийн зээлийн авлага эзэлж байна.

Насжилтын хувьд нийт зээлд /1-2 жилийн насжилттай/ 50,211.2 мянган төгрөгийн, /2-3 жилийн насжилттай/ 92,701.5 мянган төгрөгийн, 2,823.3 мянган төгрөгийн /5-аас дээш жилийн насжилттай/ зээлүүд эзэлж байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 66,737.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 386.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	1,177.8	-	(1,177.8)
Тусгай зориулалттай материал	1,177.8		(1,177.8)
Хангамжийн материал	65,946.1	66,737.2	791.1
Бичиг хэргийн материал	16,862.1	13,755.7	(3,106.4)
Аж ахуйн материал	45,012.8	50,871.1	5,858.3
Сэлбэг хэрэгсэл	243.8		(243.8)
Түлш, шатах тослох материал	2,112.0		(2,112.0)
Барилгын засварын материал	859.5	774.5	(85.0)
Бусад хангамжийн материал	855.9	1,335.9	480.0
Дүн	67,123.9	66,737.2	(386.7)

Эх сурвалж: Алтанбулаг сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТТЗ-ийн бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оныхоос 386.7 мянган төгрөгөөр буурсан нь 582,491.2 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч 582,877.9 мянган төгрөгийн материалыг зарцуулсантай холбоотой байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,237,813.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 474,065.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	1,662,527.2	2,086,668.0	424,140.80
Барилга, байгууламж, орон сууц	458,670.6	551,393.2	92,722.60
Хуримтлагдсан элэгдэл	(119,241.1)	(166,077.5)	(46,836.44)

Авто-тээврийн хэрэгсэл	232,690.6	250,590.6	17,900.00
Хуримтлагдсан элэгдэл	(192,364.8)	(114,686.3)	77,678.53
Машин тоног төхөөрөмж	275,640.0	300,264.5	24,624.47
Хуримтлагдсан элэгдэл	(64,065.4)	(117,485.7)	(53,420.37)
Тавилга, аж ахуйн эд хогшил	74,686.1	86,381.3	11,695.20
Хуримтлагдсан элэгдэл	(30,678.5)	(40,530.0)	(9,851.48)
Зам гүүрийн байгууламж	2,011,599.5	2,586,140.2	574,540.67
Хуримтлагдсан элэгдэл	(984,409.7)	(1,249,322.1)	(264,912.38)
Биет бус хөрөнгө	101,220.8	151,145.8	49,925.00
Программ хангамж	1,999.5	1,999.5	-
Хуримтлагдсан элэгдэл	(1,657.7)	(1,732.7)	(75.00)
Бусад биет бус хөрөнгө	100,879.0	150,879.0	50,000.00
Дүн	1,763,748.0	2,237,813.8	474,065.8

Эх сурвалж: Алтанбулаг сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 474,065.8 мянган төгрөгөөр өссөн нь 12,659.2 мянган төгрөгийн тавилга эд хогшил, ХХС хариуцсан мэргэжилтэнд 2,310.0 мянган төгрөгийн компьютер, ИТХ-д 1,212.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг төсвийн хөрөнгөөр худалдаж авсан, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 104,700.0 мянган төгрөгийн 2 ширхэг тээврийн хэрэгсэл /байгаль орчны байцаагч, цагдаагийн хэсэгт/, ОНХС-аар 446,309.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй өмнөх оноос шилжсэн 4 төсөл, арга хэмжээ /Мал угаалгын ванн, Ивцэг хонд голын гүүр, Хатуу хучилттай зам, Гүний худаа/ бүрэн хэрэгжсэн, ЗДТГ-аас 86,800.0 мянган төгрөгийн 2 авто машин акталснаас голлон шалтгаалсан байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 732.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,468.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	1,468.3	-	(1,468.3)
Байгууллагад төлөх өглөг	732.3	732.3	-
Дүн	2,200.6	732.3	(1,468.3)

Эх сурвалж: Алтанбулаг сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн дансны үлдэгдэлд орон нутгийн ерөнхий орлогын дансны 2000 онд үүссэн 573.5 мянган төгрөгийн өвсний үнийн өглөг /эзэнгүй олон жил болсон/, ХХС-ийн 2017 оноос өмнө үүссэн 158.8 мянган төгрөгийн насжилт өндөртэй, хариуцагч нь тодорхойгүй өрүүд байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,686,638.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 26,981.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
----------	----------------	-----------------	------------------------

Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,269,358.0	1,269,358.0	-
Хуримтлагдсан үр дүн	256,714.8	526,532.6	269,817.8
Өмнөх үеийн үр дүн	4,984,507.8	256,714.8	(4,727,793.0)
Тайлант үеийн үр дүн	(4,727,792.9)	269,817.8	(4,579,775.1)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	890,748.2	890,748.2	
Дүн	2,419,021.7	2,687,371.2	268,349.5

Эх сурвалж: Алтанбулаг сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөр цэвэр хөрөнгийн үлдэгдэл 2,687,371.2 мянган төгрөг болж 268,349.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Алтанбулаг сумын ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 18-ны 108 тоот “Тодотгосон төсөв батлах тухай” тогтоолоор нийт 621,278.7 мянган төгрөгийн татварын болон татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 693,737.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 111.7 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Хувь хүний орлогын албан татвар	300,908.1	385,430.8	84,522.7	128.1
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	251,179.8	310,315.6	59,135.8	123.5
Үйл ажиллагааны орлого	50,000.0	72,768.0	22,768.0	145.5
Хөрөнгийн орлого	31,000.0	34,544.5	3,544.5	111.4
Хөрөнгө борлуулсны орлого	16,000.0	15,074.4	(925.6)	94.2
Хувь хүний орлогын буцаан олголт	(47,271.7)	(47,271.7)	-	100.0
Хөрөнгийн албан татвар	55,400.0	59,312.6	3,912.6	107.1
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	8,000.0	6,220.7	(1,779.3)	77.8
Бууны албан татвар	1,400.0	1,236.0	(164.0)	88.3
Малд ногдуулах албан татвар	46,000.0	51,855.9	5,855.9	112.7
Бусад нийтлэг төлбөр хураамж	23,500.0	26,391.5	2,891.5	112.3
Улсын тэмдэгтийн хураамж	6,000.0	4,302.7	(1,697.3)	71.7
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,000.0	10,633.8	9,633.8	1,063.4
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	16,500.0	11,455.0	(5,045.0)	69.4
Газрын төлбөр	76,325.7	42,954.0	(33,371.7)	56.3
Газрын дуудлага худалдаа	76,325.7	42,954.0	(33,371.7)	56.3
Байгалийн нөөц ашигласны төлбөр	63,644.9	50,859.8	(12,785.1)	79.9
Ойн нөөц ашигласны төлбөр	63,052.9	49,880.0	(13,172.9)	79.1
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	592.0	979.8	387.8	165.5

Байгалийн ургамал ашигласны төлбөр		70.0	70.0	-
Нийтлэг татварын бус орлого	101,500.0	128,789.1	27,289.1	126.9
Торгуулийн орлого	80,000.0	90,653.0	10,653.0	113.3
Төсөв байгууллагын өөрийн орлого	1,500.0	862.0	(638.0)	57.5
Бусад орлого	20,000.0	37,274.1	17,274.1	186.4
Нийт дүн	621,278.7	693,737.8	72,459.1	111.7

Эх сурвалж: Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелсэн нь:

- Цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого 59,135.8 мянган төгрөгөөр,
- Үйл ажиллагааны орлого 22,768.0 мянган төгрөгөөр,
- Хөрөнгийн орлого 3,544.5 мянган төгрөгөөр,
- Малын тоо толгойн албан татвар 5,855.9 мянган төгрөгөөр,
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 9,633.8 мянган төгрөгөөр,
- Хүү, торгуулийн орлого 10,653.0 мянган төгрөгөөр,
- Бусад орлого 17,274.1 мянган төгрөгөөр тус тус давж биелснээс шалтгаалсан байна.

Төсвийн төлөвлөгөө тасарсан орлого:

- Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 1,779.3 мянган төгрөгөөр,
- Улсын тэмдэгтийн хураамж 1,697.3 мянган төгрөгөөр,
- Хог хаягдлын үйлчилгээний хураамж 5,045.0 мянган төгрөгөөр,
- Газрын дуудлага худалдааны орлог 33,371.7 мянган төгрөгөөр,
- Ойн нөөц ашигласны төлбөр 13,172.9 мянган төгрөгөөр,
- Төсөвт байгууллагын өөрийн орлого 638.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 2,044,512.5 мянган төгрөгөөр тооцсон байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 80 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 569,658.9 мянган төгрөг, урьд оны дансны үлдэгдлээс 235,183.7 мянган төгрөг, аймгаас олгох санхүүгийн дэмжлэг 601,638.6 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 315,010.1 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 83,000.0 мянган төгрөг нийт **1,804,491.3** мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 118 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 108 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 621,278.7 мянган төгрөгөөр, урьд оны дансны үлдэгдлээс 278,950.6 мянган төгрөг, аймгаас олгох санхүүгийн дэмжлэг 765,854.2 мянган төгрөг, ОНХС-аас олгох шилжүүлгийг 380,360.5 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 95,000.0 мянган төгрөг зэрэг нийт **2,141,444.0** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогоос 693,737.8 мянган төгрөг, аймгаас олгох санхүүгийн дэмжлэгээр 696,463.6 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 380,360.5 мянган төгрөг, урьд оны дансны үлдэгдлээс 278,950.6 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 90,000.0 мянган төгрөг зэрэг нийт **2,139,512.5** мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,941,601.7** мянган төгрөг буюу 90.7 хувьтай тайлагнагдсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 28,144.4 мянган төгрөгөөр, ажил олгогчийн НДШ-ийн зардлыг 5,123.8 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4,212.5 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 4,626.7 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 323.4 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 2,104.4 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 1,602.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 9,244.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэж, нийт 197,910.8 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

Сумын ОНХС-ийн эх үүсвэрээр нийт 9 төсөл, арга хэмжээнд 537,067.8 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 516,676.6 мянган төгрөгийн санхүүжилт олгон, 25,391.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 2 төсөл, арга хэмжээ хэрэгжилгүйгээр дараа онд шилжсэнээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т *“нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна”* гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн ЗДНХ-өөс 1,112.8 мянган төгрөг, аймгийн Засаг даргаас эрх шилжүүлсэн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн төсөл, арга хэмжээний зардалд 130,874.3 мянган төгрөг, аймгийн Статистикийн хэлтсээс 612.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 38,593.6 мянган төгрөг зэрэг нийт **170,580.8** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардал 32,712.5 мянган төгрөгийг, хөрөнгийн зардал 132,714.4 мянган төгрөгийг зэрэг нийт **165,426.9** мянган төгрөгийг зарцуулж, **5,153.9** мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд сумын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэхээр баталсан 105,000.0 мянган төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ, ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэхээр баталсан 405,360.5 мянган төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зорилгоор tender.gov.mn цахим хуудсанд нийт 6 удаагийн цахим тендерийн урилгыг бүрэн нийтэлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д *“Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана”* гэж заасны дагуу Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төсвийн төлөвлөлт, анхан шатны баримтын бүрдүүлэлт, үндсэн хөрөнгийн бүртгэл болон санхүүгийн байдлын тайлангийн данстай холбоотой 4 зөвлөмж өгсөн болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанбулаг сумын ТТЗ нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/104 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 1,897,914.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 18,979.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Алтанбулаг сумын ТТЗ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Батлагдсан төсвийг 9.3 хувиар хэмнэсэн,
- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Албан хаагчдын гар утасны зардал гаргаагүй, сонин хэвлэл захиалаагүй,
- Үндэсний баяр наадмаас бусад баяр ёслол, ойн арга хэмжээнд төсвөөс хөрөнгө зарцуулаагүй,
- Тус ТТЗ-ийн харьяаны байгууллагуудын эзэмшлийн 2 авто машинд тусгай дугаар авсан гэх мэт.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Огт мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	168	140	28	
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	171	167	3	1
3	Засаг даргын Тамгын газар	171	170	1	
	Нийт дүн	510	477	32	1

ТТЗ-ийн түвшинд нийт давхардсан тоогоор мэдээлбэл зохих 510 мэдээллээс 477 мэдээллийг хугацаанд нь, 32 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол огт мэдээлээгүй 1 мэдээлэл байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 122 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг

хүргүүлсэн бөгөөд тус ТТЗ-ийн 2023 оны хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар ур чадварын нэмэгдэл болон үр дүнгийн урамшууллыг илүү олгосон, төсвийг зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтгүй ажил гүйлгээг гүйцэтгэсэн, сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулаагүй, төлбөрийн цахим баримт, ашиглалтын жилийг үндэслэлгүй тогтоосон зэрэг нийт 55,879.5 мянган төгрөгийн 10 зөрчилд төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	971.7	2	971.7	100.0
Албан шаардлага	4	44,048.0	4	44,048.0	100.0
Зөвлөмж	4	10,859.8	4	10,859.8	100.0
Хариуцлага тооцуулах албан шаардлага					
Нийт дүн	10	55,879.5	10	55,879.5	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг тулган баталгаажуулах боломжгүй тул Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн болон ОНХС-ийн 2023 оны үр дүн сэдэвт гүйцэтгэл-нийцлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой нийт **6,350.0** мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулах боломжгүй тул зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв. Үүнд:

- ЗДТГ нь оны эцэст үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн 2 тээврийн хэрэгслийн ашиглагдах жилийг буруу тооцоолсон,
- ЗДТГ нь үндсэн хөрөнгийн дансанд 3,150.0 мянган төгрөгийн бараа материал бүртгэсэн,
- ЗДТГ- нь гэрээт хугацаандаа зохион байгуулагдаагүй сургалтын зардалд олгосон 2,000.0 мянган төгрөгийг урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

4. ИТХ нь бичиг хэргийн материалын дансанд бүртгэх 1,200.0 мянган төгрөгийн материалыг хангамжийн материалын дансанд бүртгэж, тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах зөвлөмж өглөө.

Аудитаар нийт **35,093.6** мянган төгрөгийн зөрчил илэрснээс 668.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 17,650.0 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 16,775.5 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт:

1. Сумын ИТХ нь төлөөлөгчдийн хоолны зардлыг бодит ирцээр бус нийт төлөөлөгчдийн тоогоор тооцож, **668.1** мянган төгрөг илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү шилжүүлсэн хоолны зардлыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага:

Сумын ТТЗ:

1. Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан **12,500.0** мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий *“Татварын хэсэгт зөөврийн байр худалдан авах”* төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр дараах ажил, гүйлгээг гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Уг худалдан авалтыг шууд худалдан авах аргаар гүйцэтгэхээр *“Баян Уул Жи Эс Би Бюльдинг”* ХХК-тай 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдөр гэрээ байгуулж, гэрээний дагуу 7,470.0 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлсэн боловч гүйцэтгэгч нь гэрээний үүргээ биелүүлээгүйгээс хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн, олгосон санхүүжилтийг санхүүгийн тайланд урьдчилж гарсан зардлаар тайлагнаагүй,
- Дахин 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр иргэн Э.Оюунбаттай зөөврийн сууцыг 11,500.0 мянган төгрөгөөр худалдан авах гэрээ байгуулан, 5,290.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч төсвийн жилд багтаан хүлээн аваагүй байна.

Өөрөөр хэлбэл уг төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийт 12,760.0 мянган төгрөг зарцуулж, төсөвт өртгийг 260.0 мянган төгрөгөөр хэтрүүлсэн боловч гэрээт хугацаанд уг зөөврийн сууцыг бэлтгэн нийлүүлээгүйгээс 12,760.0 мянган төгрөгийн авлага үүсгэж, бүртгэлд, тайланд урьдчилж гарсан зардлаар тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, сумын ИТХ-ын 2023 оны 108 дугаар тогтоол, “Баян Уул Жи Эс Би Бюльдинг” ХХК-тай болон иргэн Э.Оюунбаттай байгуулсан гэрээний холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, үүссэн авлагыг барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

Сумын ЗДТГ:

2. Сумын ЗДТГ-ын ЖМС-ийн дансыг тайлант онд хаалган, ЗДТГ-ын жолооч Ц.Отгонпүрэв, жижүүр У.Володяа, багийн Засаг дарга Э.Зориг нарын хувийн харилцах дансанд **5,150.0** мянган төгрөгийг шилжүүлэн, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр *Ибэлэн мөнгө хүссэн өргөдөл, олгох зөвшөөрөлгүй болон зарцуулалтыг нотлох гүйцэтгэлийн тайлан гаргаагүй*/ ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 3.2 дахь “Мөнгөн кассын гүйлгээг байгууллагын төсвийн эрх захирагчийн тушаал, шийдвэрээр томилогдсон мөнгөн кассын нярав хариуцан гүйцэтгэнэ”, 3.8 дахь “Мөнгөн кассын нярав нь анхан шатны орлого, зарлагын баримтыг үндэслэн мөнгөн кассын гүйлгээг хийнэ”, 3.9 дэх “Мөнгөн кассаар дамжуулан хийгдэх гүйлгээ бүрд орлого, зарлагын баримтыг бичиж байна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ЖМС-ийн дансыг нээж, байгууллагын няравт хариуцуулан, мөнгөн кассын ажиллагааны журмыг баримтлан ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Төсвийн төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн, эдийн засгийн ангиллаар үнэн зөв төлөвлөөгүй, төсвийн зохицуулалт хийх саналыг тухай бүр хүргүүлээгүйгээс бараа ажил, үйлчилгээний бусад зардлаас эд, хогшил, урсгал засварын зардалд 3,429.6 мянган төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардалд 510.3 мянган төгрөг зэрэг нийт **3,939.9** мянган төгрөгийг гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2: “Төсвийн иж бүрэн, **үнэн зөв байдлыг хангасан байх**”, 42 дугаар зүйлийн 42.3.1 дэх “Төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид, ...хүргүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13

дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн төлөвлөлтийг бодит тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөх, шаардлагатай тохиолдолд төсөвт зохицуулалт хийлгэж байх.

2. Анхан шатны баримттай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Анхан шатны баримтын бүрдэл дутуу буюу жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн заалт зэрэг үзүүлэлтүүдийг бүрэн хөтлөлгүйгээр нийт **9,280.0** мянган төгрөгийн /ЗДТГ-6,260.0 мянган төгрөг, ИТХ-3,020.0 мянган төгрөг/ шатахуун зарцуулж, бүртгэл, тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 3.3, 3.6, 6.4 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх зөвлөмж өгөв.

2.2. Илрүүлэлт: Сумын ЗДТГ, ИТХ-ын үйл ажиллагаанд ашиглагдаж буй хуучин тээврийн хэрэгслүүдийн насжилт, элэгдэл зэргийг тооцон, 100 км гүйлтэд зарцуулах шатахуунд хэмжилт, туршилт явуулж, бодит нормыг тогтоолгүйгээр жишиг нормоос хэтрүүлэн шатахуун зарцуулж, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр “Жишиг норм батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”, 3 дугаар хавсралтаар баталсан “Автомашинны шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж”-ийн холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Тээврийн хэрэгслийн шатахуун зарцуулалтад хэмжилт, туршилт хийсний үндсэн дээр нормыг тогтоож, байгууллагын даргын тушаалаар баталгаажуулж мөрдөж байх.

3. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:

3.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа **70** нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь СЭА-2024/01-НА-СТА-ТТЗ

нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг ашиглах бол дахин үнэлэх буюу актлах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх.

4. Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал

4.1.Илрүүлэлт: ОНЕО-ын дансанд бүртгэлтэй 2000 онд мал бүхий иргэдэд өвс бэлдүүлсний ажлын хөлстэй холбоотой гэх хариуцагч нь тодорхой бус, насжилт өндөр **732.3** мянган төгрөгийн өр төлбөр, 5-аас дээш жилийн насжилттай **2,823.3** мянган төгрөгийн ХХС-ийн зээлийн авлагыг барагдуулах үр нөлөө бүхий арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах,” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Насжилт өндөртэй, хариуцагч нь тодорхойгүй өр төлбөрийг данс бүртгэлээс хасах, авлагыг барагдуулах талаар хууль хяналтын байгууллагад хандаж, үр нөлөө бүхий арга хэмжээ авах.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	3	5,150.0	1	2,000.0	2	3,150.0			3	5,150.0	3	5,150.0
ИТХ	1	1,200.0			1	1,200.0			1	1,200.0	1	1,200.0
Дүн	4	6,350.0	1	2,000.0	3	4,350.0			4	6,350.0	4	6,350.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Алтанбулаг сумын ТТЗ	8	35,093.6	1	668.1	2	17,650.0	5	16,775.5				
Дүн	8	35,093.6	1	668.1	2	17,650.0	5	16,775.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Нийт 32 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг огт мэдээлээгүй		1	-					1	-
Дүн		1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Нийт дүн		1	-					1	-